

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ-НИЙГМИЙН БАЙДЛЫН 2014 ОНЫ ХОЁРДУГААР УЛИРЛЫН МЭДЭЭЛЭЛ

2014.07.05

Алтай хот

Мал тооллого: Хагас жилийн мал тооллогыг сумууд бие даан явуулж тооллогын эцсийн нэгдсэн дүнгээр бүгд хоёр сая 900.0 мянган мал тоологдсоны дотор тэмээ 35.0, адуу 77.7, үхэр 50.5, хонь 901.1, ямаа нэг сая 835.7 мянган толгой мал тус тус байна. Үүнээс төллөх насны хээлтэгч бүгд нэг сая 82.9, ингэ 10.1, гүү 19.2, үнээ 16.4, эм хонь 352.3, эм ямаа 684.7 мянган толгой тоологдлоо.

Төл бойжилт: Аймгийн дүнгээр 915.7 мянган толгой буюу төллөх насны хээлтэгчийн 90.8 хувь төллөж, 808.4 мянган төл 97.2 хувиар бойжиж байна. Төллөх ингэний 49.0, гүүний 75.5, үнээний 79.1, эм хонины 93.4, эм ямааны 90.9 хувь тус тус төллөж, 100 эхээс ботго 48, унага 74, тугал 77, хурга 92, ишиг 88-ийг бойжууллаа. Гарсан төлөө Алтай, Бугат, Дарив, Дэлгэр, Тайшир, Тонхил, Төгрөг, Халиун, Хөхморьт, Чандмань сумд 91.4-98.8 хувиар тус тус бойжуулж, харин Баян-Уул, Бигэр, Жаргалан, Цогт, Цээл, Эрдэнэ, Есөнбулаг сумуудын төлийн хорогдол 63.1 хувийг эзэлж байна.

Мал онд оролт: Аймгийн мал сүрэг 99.1 хувиар онд орж, бүгд 26.5 мянган том мал зүй бусаар хорогдсон нь өмнөх мөн үеэс 15.1 хувиар бага байна. Бигэр, Тайшир, Халиун, Цээл, Эрдэнэ сумд 1.5-4.5 хувиар малаа хорогдуулсан нь нийт хорогдлын 74.7 хувийг эзэлж байгаа ба бусад сумууд малаа 99.4-99.8 хувиар онд оруулжээ.

Хээл хаялт, сувайралт: Аймгийн төллөх насны хээлтэгчийн 2.0 хувь буюу 18.6 мянган хээлтэгч хээл хаяж, мөн хээлтэгчийн 4.7 хувь буюу 42.9 мянга нь сувайрсан байна. Алтай, Бигэр, Бугат, Дэлгэр, Тайшир, Тонхил, Төгрөг, Хөхморьт, Чандмань, Шарга сумд хээл хаялт багатай, Баян-Уул, Дарив, Халиун, Цогт, Цээл, Есөнбулаг сумд хээл хаялт их байна. Алтай, Бугат, Дэлгэр, Тайшир, Тонхил, сумдад сувайралт бага, Баян-Уул, Жаргалан, Халиун, Төгрөг, Хөхморьт, Чандмань сумдад сувайралт их байна. Энэ онд хээл хаяж сувайрсан шалтгаанаар нийт хээлтэгчийн 6.7 хувь буюу 61.5 мянган хээлтэгчээс төл авч чадсангүй.

Тариалалт: Үр тариа 490.7 га-д үүнээс улаан буудай 296.8 га, төмс 109.2 га, хүнсний ногоо 71.9 га, эмийн ургамал 131.0 га, жимс, жимсгэнэ 131.0 га, малын тэжээл 415.3 га, нийт 1237.6 га-д тариалалт хийлээ. Өнгөрсөн оноос тариалсан талбай бүх төрөл дээр буурчээ.

Хилийн худалдаа: 3 удаа хилийн худалдаа хийгдэж 61.3 сая ам долларын төмрийн хүдрийн баяжмал гаргаж, цемент, цагаан будаа болон бусад тоног төхөөрөмж сэлбэг хэрэгсэл зэрэг 4.6 сая ам долларын бараа материал оруулж ирэв.

Үнэ: Малчдын орлогын зонхилох хувийг бүрдүүлдэг ямааны ноолуурын үнэ түүвэр судалгаанд сонгогдсон Алтай хотод сарын эцэст доорхи ханштай байлаа.

Сарууд	I	II	III	VI	V	VI
1 кг ноолуурын үнэ /мянган төгрөг/	60.0	63.0	50.0	70.0	68.0	66.0

Аймгийн хэрэглээний бараа үйлчилгээний үнийн индекс түүвэр судалгаанд хамрагдсан Алтай хотод 6 дугаар сарын 21-ний байдлаар өмнөх сараас 0.3 хувиар, өнгөрсөн мөн үеэс 13.2 хувиар тус тус өссөн байна.


Аж үйлдвэр: Тайлант хугацаанд Алтай-Улиастай Эрчим хүчний систем, Мандал голомт, Тулга-Алтай, Ентүм, Ундрам-оюу, Шимт дээж, Ундарга-Алтай, Баярт олон, Залуур-Алтай, Даянтайшир, Ариун өргөө, Айргийн хад, Дуурсах-Алтай зэрэг 56 аж ахуйн нэгж, 86 хувиараа үйлдвэрлэл эрхлэгчид үйл ажиллагаа явууллаа.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл оны үнээр, 5 тэрбум 647 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 850.9 сая төгрөг буюу 13.1 хувиар, үүнээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарынх 164.6 сая төгрөг буюу 47.5 хувь, боловсруулах аж үйлдвэрийнх 92.8 сая төгрөг буюу 17.8 хувиар өсч, харин цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарынх 1 тэр бум 108.2 сая төгрөг буюу 19.7 хувиар буурлаа.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеийнхээс амтат ус, ундаа, арвайн гурил, хуванцар цонх үйлдвэрлэл 1.5-11.8 дахин өсч, нүүрс, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, сувагжуулалт, талх нарийн боов үйлдвэрлэл нь 6.5-65.3 хувиар өсч, харин гутал ботинк, архи дарс, блок, улаан тоосго, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл 17.1-66.4 хувиар буусан байна.

Аж үйлвэрийн бүтээгдэхүүн үйлвэрлэлийн 87.5 хувийг Есөнбулаг, 2.4 хувийг Тайшир, 2.2 хувийг Дарив, 1.5 хувийг Чандмана, 1.1 хувийг Эрдэнэ, Дэлгэр, 0.8 хувийг Цээл сумдад, 0.7 хувийг Цогт, Бигэр, 0.6 хувийг Алтай сумдад эзлэж байгаа нь эдгээр сумдад үйлдвэрлэл илүү хөгжиж байгааг харуулж байгаа ба үлдсэн 0.7 хувийг бусад сумд эзлэж байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 4 тэрбум 985.7 сая төгрөг болж, нийт бүтээгдэхүүн үйлвэрлэлийн 88.3 хувийг борлуулжээ.



Барилга: Эхний хагас жилийн байдлаар барилга угсралт, их засвар гурван тэрбум 384.1 сая төгрөгийн ажил хийж, үүнээс гурван тэрбум 69.4 сая төгрөгийн шинэ барилга, 314.5 сая төгрөгийн их засварын ажлыг гүйцэтгэсэн байна.

Төсвийн орлого: Орон нутгийн төсөвт дөрвөн тэрбум 253.7 сая төгрөг оруулж, төлөвлөгөөг 102.8 хувиар, улсын төвлөрсөн төсөвт 420.7 сая төгрөг оруулж төлөвлөгөөг 99.4 хувиар тус тус биелүүлж, аймгийн төсвийн нийт орлого дөрвөн тэрбум 674.5 сая төгрөг болж төлөвлөгөөг 102.5 хувиар давуулан биелэлсэн байна.

Үүнээс татварын орлого 100.2 хувиар биелсэн байна. Улсын болон орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг Алтай, Баян-Уул, Бигэр, Бугат, Дарив, Дэлгэр, Жаргалан, Тайшир, Халиун, Хөхморьт, Цогт, Чандмань, Цээл, Шарга, Есөнбулаг сумд 1.2 хувиас 2,9 дахин давуулж, улсын төсвийн орлогын төлөвлөгөөг Төгрөг сум, Гуулин тосгон 19.4-15.3 хувиар тасалсан байна.

Төсвийн зарлага: Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилтын 72.1 хувийг санхүүжүүлэв. Үүнд цалин хөлс нэмэгдэл урамшууллын төлөвлөгөөний 95.0, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн 92.8, бараа үйлчилгээ бусад зардлын 124.9 хувийг тус тус санхүүжүүлсэн байна.

Банкны мөнгөн орлого, зарлага: Бүгд 15 тэрбум 410.1 сая төгрөгийн зузаатгал хийж кассын гүйлгээнээс 177 тэрбум 431.9 сая төгрөг татаж, монгол банкинд 14 тэрбум 43.0 сая төгрөг шилжүүлж, гүйлгээнд 189 тэрбум 316.5 сая төгрөг гаргалаа. Зээлийн өрийн бүх үлдэгдэл 76 тэрбум 117.9 сая төгрөг байгаагаас хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 0.2 хувийг эзэлж байна. Иргэдийн хадгаламж өнгөрсөн оны мөн үеэс 1.6 хувиар нэмэгджээ.

Хүн ам: Эхний хагас жилийн байдлаар 671 эх амаржиж, 674 хүүхэд мэнд төрлөө. Одоогоор аймгийн хэмжээнд эмнэлгийн хяналтанд авагдсан 618 жирэмсэн эхчүүд байна. 1 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 18 тохиолдол бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн 323 халдварт өвчний өвчлөл дотроос гепатит 1.2, бэлгийн замын халдварт өвчнүүд 43.9, сүрьеэ 5.5 хувийг тус тус эзэлж байна. Хорт хавдараар өвчилсөн 78 тохиолдол шинээр бүртгэгдсэн ба энэ өвчнөөр нас барсан 46, осол гэмтлээр нас барсан 20 тохиолдол бүртгэгдлээ. Тайлант онд эрүүл мэндийн байгууллагын эмч мэргэжилтнүүд давхардсан тоогоор 131.6 мянган хүнд үзлэг хийж, 8.1 мянган хүнийг хэвтүүлэн эмчилж, 63.8 мянган ор хоног ашиглажээ.

Аудитын газар: Санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудитыг 215 байгууллагын 291 санхүүгийн тайланд аудит хийлээ. Санхүүгийн тайланд аудит хийсэн дүнгээс үзэхэд 208 санхүүгийн тайланд зөрчилгүй, 76 санхүүгийн тайланд хязгаарлалттай, 7 санхүүгийн тайланд сөрөг дүгнэлт өглөө. Өмнөх оноос аудитын тоо 87-оор өссөн бол зөрчилгүй дүгнэлтийн тоо 126-аар, хязгаарлалттай дүгнэлтийн тоо 39-өөр өсч, сөрөг дүгнэлтийн тоо 3-аар тус тус буурсан байна.

Аудитаар 106 тэрбум 737.5 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлсэний 4.0 хувийг буюу 4.3 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 100 тэрбум 70.6 сая төгрөгийн зөрчлийг засаж залруулах 464 заалт бүхий албан шаардлага, 55 заалт бүхий зөвлөмж өгч, 1429.2 сая төгрөгийг төсвийн орлого болгохоор төлбөрийн акт тогтоолоо. Аудитаар илэрсэн зөрчлөөс хамааран 30 албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд саналаа хүргүүллээ.

УИХ-ын төсвийн байнгын хорооны захиалга, Үндэсний аудитын газрын төлөвлөгөөгөөр МУ-ын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэнд гүйцэтгэлийн аудит хийлээ.

Мэргэжлийн хяналтын газар: Эхний хагас жилийн байдлаар 336 байгууллага, 36 салбар нэгж, 1523 хүнийг хамарсан мэргэжлийн хяналт хийж, 1563 зөрчил илрүүлсний 46.8 хувийг газар дээр нь арилгуулав. Байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдийн зөрчилтэй үйл ажиллагааг засахад чиглэгдсэн 8 сая 255.4 мянган төгрөгийн торгууль тавьж барагдуулалт 83.7 хувьтай байна. Мөн гаргасан дүгнэлтийн 35, албан шаардлагын 25.9 хувийг биелүүлээд байна. Хагас жилийн байдлаар 1 байгууллагын үйл ажиллагааг бүрэн зогсоож, 7 байгууллагын үйл ажиллагааг түр зогсоожээ. Бүгд 21 байгууллагын санхүүгийн баримтанд шалгалт хийж 34.1 сая төгрөгийн акт тавьсны 80.1 хувийг барагдуулаад байна.

Хөдөлмөрийн хэлтэс: Эхний хагас жилийн байдлаар хөдөлмөр эрхлэхийг хүсч бүртгүүлсэн ажилгүйчүүд 1334 болсны дотор 60.3 хувь буюу 805 нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгүүлсэн ажилгүйчүүдийн 313 нь дээд, 192 нь тусгай дунд, 56 мэргэжлийн анхан шатны, 536 нь бүрэн дунд, 155 нь бүрэн бус дунд, 59 нь бага, 23 нь ямар ч боловсролгүй хүмүүс байна. Тус алба тайлант хугацаанд 160 хүнийг түр болон бүр ажилд ороход нь зуучлав.

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс: Хагас жилийн байдлаар 9.1 мянган хүнд 2278.8 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт олгожээ.

Биеийн тамир спортын хороо: Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 8 төрлөөр 108 тамирчин оролцоноос шатраар алтан медаль, жу-до бөхөөр мөнгө, хүрэл медаль тус тус хоёрыг авсан байна.

Баруун бүсийн тэмцээнд 4 төрлөөр 136 тамирчин оролцож жу-до бөхөөр алтан, мөнгөн, хүрэл 6-г тус тус, волейболоор мөнгөн медаль, таеквондогоор мөнгөн медаль 4, хүрэл медаль 10 тус тус авсан байна.

Ахмадын улсын аварга шалгаруулах тэмцээнд 2 төрлөөр 15 тамирчин оролцож Жү-до бөхөөр алт, мөнгө, хүрэл, уулын авиралтаар алт, хүрэл медаль авсан байна.

Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд 4 төрлөөр 18 тамирчин оролцож таеквондогоор 1 алт, шатраар 1 алт, спорт авиралтаар 1 хүрэл, пара хөнгөн атлетик 3 алт, 4 мөнгө, 3 хүрэл медаль тус тус авсан байна.

Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнд уулын авиралтаар 6 алт, 6 мөнгөн медаль авсан байна.

Стандарчилал, хэмжил зүйн төв: Тус төв “Чанарын баталгаажуулалтанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт”-д орсон бүтээгдэхүүн, ажил үйлчилгээнд тохирлын үнэлгээ явуулж стандартын шаардлага хангасан 4 аж ахуй нэгжийн 5 нэрийн 4 бүтээгдэхүүнд “Тохирлын гэрчилгээ” олгожээ. Хэмжүүрийн лаборатори механик хэмжүүр, цахилгаан хэмжил, эзэлхүүн багтаамжийн төрлөөр нийт 27 аж ахуйн нэгж иргэний 146 ширхэг хэмжүүр хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалтанд хамруулсан байна.

СХЗГ-н стандарт, мэдээлэл лавлагааны төвөөс шинээр батлагдсан болон шинэчлэгдсэн стандартыг цахим хэлбэрээр захиалан авч 64 аж ахуйн нэгж, иргэнд 165 стандартаар үйлчилжээ.

Аймгийн Хөдөө аж ахуйн газар: Нийт 1974.5 мянган толгой мал халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдахаас 1854.5 мянган мал хамрагдаж 93.9 хувьтай байна. Засгийн газраас хэрэгжүүлж буй Таван Эрдэнэ нэгдсэн арга хэмжээний хүрээнд малын паразиттах өвчний эсрэг боловсруулалтын арга хэмжээнд 483.5 мянган малыг хамруулсан байна. Аймгийн дүнгээр 24.9 мянган бог малд үзлэг ангилалт, хийж үүнээс 8.4 мянган малыг цөм сүрэгт бүртгэж, 7.6 мянган богийн хээлтүүлэгчид үзлэг аттестатчилал явуулж 7.5 мянган хээлтүүлэгчийг үржилд баталгаажуулан үндсэн сүргээс нь ялган маллаж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын газар: Бүх нийтээр мод тарих, орчиноо цэцэрлэгжүүлэх ажлыг зохион байгуулж аймгийн хэмжээнд нийт 233.7 мянган мод тарьж 131 аж ахуй нэгж байгууллага, 1860 иргэн оролцож 23.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

“Ус” Үндэсний хөтөлбөрийн хүрээнд Есөнбулаг сумын Түмэнгийн булаг, Соохойн булаг, Хөх дэнжийн булаг, Ус-Алтай доод булаг болон нисэх буудлын далан, сутагч хорооны нуур, Харзат багийн урд дэрс, ус цэвэршүүлэх станцын орчмын хог хаягдлыг ЭМШУИСургууль, МСҮТ, 11 жилийн 1, 3, 5 дугаар сургуулийн ажилчид, оюутан, сурагчид хамтран 1265 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, 20.5 тонн хогийг цэвэрлэж хогийн цэгт төвлөрүүлсэн байна.

Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар: Энэ онд аймаг, сумын Засаг даргын 1 удаагийн захирамжаар 19 иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчлүүлсэн. Одоогийн байдлаар аймгийн хэмжээнд 5356 иргэнд 516.9 га газрыг өмчлүүлсэн нь нийт хүн амын 9.8 хувийг эзэлж байна.

Энэ оны эхний хагас жилд гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан үнэгүй өмчлүүлснээс одоо эзэмшиж, ашиглаж байгаа хашааны газар 19 иргэнд 1.5 га газрыг өмчлүүлсэн байна.

Ерөнхий боловсролын сургуулиуд: Ерөнхий боловсролын 28 сургууль, 27 цэцэрлэгт өсвөр үеийг сурган хүмүүжүүлж байна. Эдгээр сургуулиудад 11.9 мянган сурагч суралцаж, цэцэрлэгт 4.1 мянган хүүхэд хүмүүжиж байна. Энэ хичээлийн жилд тавдугаар ангийг 1110, есдүгээр ангийг 1216, арван нэгдүгээр ангийг 904 хүүхэд төгсгөлөө.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв: Энэ хичээлийн жилд 758 суралцагчид сурч, нийт 74 ажиллагсад, мэргэжлийн 35, ерөнхий боловсролын 14 багштай ажиллаж байна. 2013-2014 оны хичээлийн жилд 11 мэргэжлээр 291 хүүхэд төгсжээ.

Тэгш-Алтай: Авто машины жолоочийн дамжаагаар 72 хүнд “В” ангиллын жолооч мэргэжил эзэмшүүллээ.

Батлан Хамгаалахад туслах Нийгэмлэг: Авто машины жолоочийн дамжаагаар 9 хүнийг “В” ангиллаар жолооч мэргэжил эзэмшүүллээ.

Ихэс-Алтай: Авто машины жолоочийн дамжаагаар 32 хүнд “В” ангиллын жолооч мэргэжил эзэмшүүллээ.

Авто тээвэр: Зорчигч, ачаа тээврээр байгууллага иргэдэд үйлчилж 445.6 сая төгрөгийн орлоготой ажиллав.

Нефть хангамжийн бааз: 1 тэрбум 402.1 сая төгрөгийн шатахуун тосолгооны материалыг татан авч 7 тэрбум 582.7 сая төгрөгийн шатахуун тосолгооны материалын борлуулалт хийлээ.

Цахилгаан холбоо компани: Суурин телефон цэгийн тоо 808, холбоо ашиглалтын орлого 125.0 сая төгрөг, үүнээс хүн амаас орсон орлого 78.5 сая төгрөг болжээ. Интернетийн үйлчилгээний 1 цэг 19-н суудалтай ажиллаж интернетээр дунджаар 4.4 мянган хүнд үйлчилжээ.

Шуудан үйлчилгээний газар: Сум, хот, хооронд шуудан, хэвлэл захиалга, илгээмж, зорчигч тээвэр үйлчилж бүгд 44.2 сая төгрөгийн орлоготой ажиллав.

Мобиком корпорацийн Говь-Алтай дахь салбар: Тус салбар үндсэн хэрэглэгч 0.9 мянга, урьдчилсан төлбөрт карт эзэмшигч 21.9 мянга, бүгд 22.8 мянган хэрэглэгчдэд үүрэн телефоноор үйлчилгээ үзүүлж байна.

Юнител ХХК-ний Говь-Алтай дахь салбар: Тус салбар нь үндсэн хэрэглэгч 0.8 мянга, урьдчилсан төлбөрт карт эзэмшигч 16.1 мянга, бүгд 16.3 мянган хэрэглэгчтэй байна.

Ж-Мобайл ХХК-ний Говь-Алтай дахь салбар: Тус салбар нь дараа төлбөрт 0.9 мянга, урьдчилсан төлбөрт 22.3 мянган хэрэглэгчтэй болоод байна.

Зэрэглээт-Алтай ХХКомпани: Тус компани нь 0.4 мянган хэрэглэгчтэй 6.9 сая төгрөгийн орлоготой ажиллажээ.

Миний нутаг телевиз: Мэдээ, сонины тоймыг 92 цаг, хүүхэлдэйн болон уран сайхны киног 420 цаг, зар сурталчилгааг 45 цаг, захиалгат болон шууд нэвтрүүлгийг 15 цаг, шууд болон захиалгат нэвтрүүлгийг 98 цаг цацан гаргасан байна.

Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс: Тус хэлтэс нь амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 5 өрхийн 16 хүүхдэд “Дэлхийн зөн ОНХХ”-тэй хамтран тус бүр 200.0 мянган төгрөгийн хүнсний болон ахуй хэрэгцээний тусламж үзүүлжээ.

Гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн ажлын хүрээнд эцэг, эхчүүдийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, үлгэр жишээ эцэг, эхийг сурталчилах, гэр бүлийн харилцааны тулгамдсан асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргах зорилгоор “Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгаалал” чуулганд 35 төрийн байгууллагын, 105 гэр бүл, 10 төрийн бус байгууллагын нийт 150 хүн оролцлоо. “Цодгор хүү-2014”, “Хүрэл тулга-2014”, “Мөнгөн хонх”, “Би страдын дуучин-2014” зэрэг наадмуудыг зохион байгуулан явуулж эхний байруудад орсон хүүхдүүдийг шагнаж урамшуулсан байна.

Ардын дуу Бүжгийн “Алтай” чуулга: Нийт 13 удаагийн тоглолт хийж 7.9 мянган үзэгчид үзжээ. Нийт 5.8 сая төгрөгийн орлоготой ажилласан.

Аймгийн музей: Онцгой болон түүх дурсгал, эд өлгийн 2.5 мянган үзвэрээр 1.1 мянган үзэгчдэд үйлчилж 1.1 сая төгрөгийн орлоготой ажиллав.

Аймгийн номын сан: Эхний хагас жилд шинээр 450 уншигч бүртгэж 4.1 мянган уншигчдад 25 төрлийн тогтмол хэвлэл, 1.7 мянган номоор үйлчилж, уншигчдын эрэлт хэрэгцээг ханган шинэ мэдээ мэдээллээр түргэн шуурхай үйлчлэх зорилгоор 105 аман болон бичгийн лавлагаа өгч, 265 ширхэг ном сэлбэн зассан байна.

Онцгой байдлын хэлтэс: Галын дуудлаганд 17 удаа гарч, 9.0 мянган айл өрх, 375 объектод урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийж зөвөлгөө өгч, 114.4 сая төгрөгийн хөрөнгийг гал түймрээс аварчээ. Хүмүүсийн болгоомжгүй үйл ажиллагаанаас шалтгаалж гал түймрийн улмаас 13.9 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирлаа. Хагас жилийн байдлаар 17 удаагийн гал түймэр гарсны 11-ийг нь онцгой байдлын хэлтэс, үлдсэн 6-н түймэрийг иргэд өөрсдөө унтраасан байна.

Гамшгийн мэдээ: Онцгой байдлын эрэн хайх, аврах бүлэг 7 удаа техникийн болон ослын холбогдолтой дуудлага хүлээн авч ажилласан байна.

Гэмт хэрэг: Эхний хагас жилд байгууллага иргэдийн 160.1 сая төгрөгийн өмч хөрөнгөнд хохирол учруулж, 96 гэмт хэрэг гарч, эдгээр хэргүүдээс хулгай гэмт хэрэг, үүнээс орон байрны хулгай, бусдын бие махбодид гэмтэл учруулсан гэмт хэргүүд дийлэнх хувийг эзлэж байна. Гарсан нийт хэргийн 58.3 хувь нь Есөнбулаг сумд гарсан хэрэг эзэлж байна.

Баривчлагдсан хүний тоо өмнөх мөн үеэс 12 хүн буюу 9.8 хувиар, тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүний тоо өмнөх онтой харьцуулахад 36 хүн буюу 26.2 хувиар өссөн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба: Энэ онд 158 гүйцэтгэх хуудасны хоёр тэрбум 664.3 сая төгрөгийн төлбөрт шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагаа явуулж үүнээс 91 гүйцэтгэх хуудасны 89.5 сая төгрөгийн төлбөрийг бодитойгоор биелүүлсэн байна. Мөн 134 тэтгэлэг төлөгчөөс 65.9 сая төгрөгийн тэтгэлэг гаргуулахаас 42.9 сая төгрөгийн тэтгэлгийг бодитойгоор гаргуулсан ба бодит биелэлт 65.0 хувьтай байна.